

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чойжилийн Рэнчинсүрэн	Дугаар	L032
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянзүрх дүүрэг
Төрсөн газар	Завхан аймгийн Цагаанхайрхан сум	Төрсөн он	Хулгана жилтэй
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дуутын хүрээ	Сүм хийдийн дугаар	ЗАЦХ 065
Одоогийн сүм хийд	Дашчойлин хийд	Сүм хийдийн дугаар	UB 02
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Дуутын хүрээ

Дуутын хүрээнд 7 настайгаасаа суусан. Дуутын хүрээ нь одоогийн Завхан аймгийн Цагаанхайрхан сумын нутагт байдаг. Хүрээ нь Цэцэг уулын өвөрт байдаг байсан. Тэнд Агьтын ам гэж байсан. Сумын наадхан дэнж дээр Агьтын хүрээ гэж байсан. Урд ардаа Асгат гэж том уул байсан. Хойшоо их замаар ороод Ганцын даваагаар даваад Улиастай руу орно. Урдах гол нь Ширээгийн гол гээд байдаг байсан. Манай хийдээс Отгонтэнгэрийг тахидаг байсан. 3 жил тутам хошуу 6 баг нийлээд тахидаг байсан. Хошууч бэйсийнхэн өөрсдөө нийлээд тахидаг байсан. Намайг сууж байхад л 100 гаруй жил болж байна гэж хэлдэг байсан юмдаг. Сор залахад зүгийг нь 100 гаран насаар үзэж байсан юм.

Миний үед 2000-аад ламын данстай гэдэг байсан. Цогчэн, Чойр, Дүйнхор, Манба, Ламрим, Дэмид, Жүд, Равсанжүр, Дарь-Эх, хоёр Нүгнээ гээд 11 дацан, дугантай. Осор-Дэмид гэдэг нь Нарбанчэн гэгээний дацан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ламрим гэдэг нь Дилав хутагтын дацан. Равсанжүр гэдэг чинь нэг тийм тусдаа Цогчин дуган байсан юм. Төвд нэр мэдэхгүй. Дуутын хүрээ л гэдэг.

Миндагтнууд их олон. Дацан тус бүрдээ миндагтангуудтай. Гавж, дооромбо, аграмба. Харин Мамбын дацанд маарамбын дамжаа барьж байгаагүй. Чойрт дооромбо болж байсан. Манайд гавж гэдэггүй байсан. Аграмба гэхээр их том болоод явчихна. Дээр үедээ Төвдийн лам Арь гэгээн гэж хүн хамба нь байсан. Намайг байхад Гэндэн хамба гэж байсан. Тэгээд Мяндаг гэдэг лам хамба суусан. Тэгээд л арилсан. Цогчэн унзад, гэсгүйгээр бага шиг бага шиг улсууд л байсан даа. Хамгийн сүүлд нь Чоймбол, аварга Равдан гэж 2 гэсгүй байсан. Цогчин унзад нь тапа Лувсан, поолгор Сэрээт гэж байсан. Шар Лут гэж байсан. Дээр үед Хайсагийн ширээт гэдэг хүн байсан юм гэнэ лээ, Тэрнийг би муухан мэднэ. Хамгийн том ширээт нь тэр байсан.

Хийдийн гол шүтээн нь Банданлхам, Лхам, Гомбо, Чойжоо, Жүдийнх Гомбо, Цогчэнгийнх Чойжоо, Ламримынх Гомбо, Манбынх Очирваань, Дамжин, Чойрынх Улаан сахиус, Сэтэв Чойжин, Сэндом байсан. Дүйнхорынхыг мэдээгүй.

Дуутын хүрээнд ер нь Хошууч бэйсийнхэн л сууж байсан юм. Хаа нэг л энд тэндээс ирдэг. Би Чойр, Цогчин, Ламримд хурж байсан. Чойрт умын зиндаа, гаарамба хүртэл явсан. Гүнчин ламын игчаатай байсан. Нийтдээ чойрын 10 зиндаа байсан. Хадаг, шидүв, жумбарай, юлжин, дагариг, дондонжу, парчин, ум, жод, гаарамба. 10 жил болоход дом хийгээд гарна. 10 жил болохгүй ч гарна. Номтой номгүй эрэмбээрээ өгсөөд л явчихна. Манай зиндаанд 50, 60-аад лам байсан байх. Сүүлдээ лам нь цөөрсөн. Нэмж лам болгодоггүй. Түрүүнийх нь хөгшин лам нар нь үхээд. Ингэж байсан юм. Ер нь 2000 лам байсан. Хурал тарж байгаа, тараагүй хоёр нь мэдэгддэггүй л байсан юм.

Лаврин дэгтэй байсан. Сарын хурлууд дүйчэн, дүйчэнгүүдээ янз янз л хурна. Шинийн 8-нд Минтүг, Гүнрүг хурж, сахиуснуудаа тахина. Чойрынх дүйчэнтэй, Равсанжүрийнх дүйчэнтэй. Цагаан сараар Чонпрүл жон а хурна. 15 хоногийн хурал. Хуучин хурал гэдэг бол эндхийн үг. Өвлийнхөө хурлыг тэгж хэлдэг. Манайх бол өвлийн хурал л гэнэ. Өвлийн адаг сарын 29-нд сор зална. Зуны адаг сарын 29-нд сор зална. Цэдор Лхамаа уншина. Өвөл бол хөдөөнөөс сүсэгтнүүд нэг их ирж чадахгүй харин зун их ирцгээнэ. Өвөл манай хүрээ улсуудаасаа хоцорчихдог хангай газар. Айлууд нь доошоо уруудаад нүүчихнэ. Тэрүүхэн тэндээ байдаг борчууд л ирнэ. Ирлээ гээд 150-иас олонгүй хүн л байсан байх. Зун бол их ирнэ. Зуны адаг сарын шинийн 4-нд Майдар эргэнэ. Тэнд цамтай. Зуны адаг сарын 29-нд сороо залаад цам гарна. Сорын цамд 120 хүн гардаг тогтоолтой. Цамын дэг нь ламрин байсан. Хошууч бэйсийн хошуунд манай хүрээнээс их хүрээ байгаагүй. Бусад нь жаал жаахан хүрээ байсан. Агьтын хүрээ жаахан, Дэлгэр багийн хүрээ жаахан, Отгоны 2 жаахан. Манайх хамгийн том нь байсан юм. Тэрэн дээр л би нэг хэд хоносон (9 жил) юм. Майдар, Ганжуур эргэнэ. Зуны адаг сарын шинийн 4-нд Майдар эргэнэ. Ганжуураа 7 хоног хурна тэгээд л эргэнэ дээ. Ханиад, томуу ихтэй бол их олон эргэнэ. Ханиад, томуу бага бол бага л эргүүлнэ. Тогтоолтой эргүүлэх нь зуны адаг сарын шинийн 4-нд. Хайлан хурна. Хайланд суух ламын тоо жил жилээсээ хамаарна. Тогтоол байхгүй. 70, 80-аад л хүн лав хурна. Дандаа гэлэн, гэцлүүд хурна. Нүгнээ сахиж байсан. Баруун Нүгнээ, Зүүн Нүгнээ гэж хоёр дуган байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хийдийн дуганууд нь хятад маягийн, модон дуганатай байсан. Манай тэнд мод ихтэй, модон дотроо байдаг шахуу газар юм. Хятадууд л барьсан байлгүй дээ. Хоёр туйпуу дуган байсан. Арь гэгээний дуган, Чойрын дуган хоёр туйпуун дуганууд байсан. Хамгийн сүүлд Цугаараа дээрээ нэг давхар оройтой тийм дуганууд байсан юм. Харин Гэгээний хүрэн (Нарбанчэн) дээр л 7 давхар дуган байсан. Орой дээр нь хурал хурдаг юм байхгүй. Давхар давхар орой байсан юм. Тэр 7 чинь дөрвөн өнцөг дээр нь нэг, нэг дээрээ 3 давхар байсан. Тэр 7 оройтынхоо хойд талд 3 давхар гоё байр байсан. Гэгээн хүрээний лам нар цөөхөн.

Манай хийдэд Жанчив чодэн суваргууд байсан. Хэрмэн хашаа байгаагүй. Хэрмэн хашаатай хүрээ манайд Яруугийн хүрээнээс ондоо байгаагүй. Лам нар аймаглаж суудаггүй байсан. Зиндаа зиндаагаараа сууна. Чойрт хурдаггүй хүн гэж ховор. Чойрын 3 дуган байсан. Тэндээ багтвал их юм болдог байсан. Дан Цогчэнд хурдаг хөгшчүүл ч байсан. Их нарийн хатуу дэгтэй байсан. Лам нарын гэр нь баруун урд талаасаа эхлээд хойгуураа үргэлжлээд зүүн урд тал хүртлээ байна. Урдуур ерөөсөө байдаггүй байсан.

Хийдийн ойролцоох борчууд нэлээд зайтай. Их өндөр уултай газар. Тэрнийхээ завсар завсарт нь байсан юм. Хийдийн зүүн урд талд нь нэлээн холхон Түнжүсийн гэдэг айл байсан. Гэхдээ явган яваад л байдаг. Хоёр ч пүүс байсан. Дархан хятадууд ч байсан.

Манай хийдтэй ойролцоо хийд нэг их байгаагүй. Яруугийнх чинь хойд руугаа. Агьтынх, Дэлгэр багийн, Отгоны хоёр, Хоёр багшийн хүрээ (Нарбанчэн гэгээний хүрээ) манайхтай ойролцоо. Хошуу хүрэн дээрээ том хурал хурвал нийлж хурна. Манайд Төвд лам гэж байгаагүй. Арь гэгээн бол Төвд лам байсан. Арь гэгээний дараа Дилав лам хамба суусан.

Дугана тус бүр жастай. Хамгийн том жас нь 2 цогчин байсан. Намайг бага шиг байхад тэд чинь мөнгөөр дарлаад тэд хуу байхгүй болсон. Татвар аваад хамаг юмаа худалдаж өгөөд сүүлдээ дуганаа хүртэл худалдаж өгөөд байхгүй болсон.

Өдөр тутам дацангийнхаа дэгийг л барина. Гэлэн гэлэнгийнхээ дэгээр явна. Шажин, төр хоёр нь хос, түүнийгээ л дагаж явна. Төрдөө ноён нь ноёндоо хийд нь захирагдана. Хайлантай үед эмэгтэй хүн хүрээнд хонохгүй. Сүсэгтнүүдийн уншуулна гэсэн номыг л уншина. Зоч лам нар хөдөөгүүр явна. Хөдөөгүүр явдаг 4, 5 хүн байсан болов уу даа. Бид чинь 2 өөр замынх.

Хийд 1938 онд хаагдсан. Хэдэн лам нарыг нь хуу аваачаад. Залуучууд нь хөдөө гарч хар болоод. Тэгээд л хаагдсан. Ном судар, бурхан тахилууд нь алга болсон л байсан. Тэр үед чинь хүн бүр л айгаад тэрний хойноос явдаг хүн байгаагүй. Хийд маань дахин сэргээгдээгүй.

Би Нарбанчэнгийн хийд дээр очиж байсан. Мөргөх гэж очиж байсан. 3 давхар нэг гоё дуган байсан. 7 оройтой нэ дуган байсан. Гэгээн багшийн тугдам урд толгойн хажууд байсан. Тэрүүхэн хажуухан талд нь нүгнээнх гэж шавар дуган байсан. Тэрнээс хойхно Дилав багшийнх байсан. Цөөхөн лам нартай тийм л хийд байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Би Чойр, Цогчэн 2-ыг заалгаж байсан. Дооромбын дамжаа хавар нэг, намар нэг барина. Нэг удаад 2 юм уу 3 хүн л барина. 400, 500 хүн оролцоно. Дамжаа барихад 1 лам 2 өдөр даана. Аграмба 300, 400 хүн байвал овоо нь тэр.

Гончиг зурхайч гэж байсан. Дамдинсүрэн зурхайч гэж байсан. Очирбат гэж зурхайч байсан. Шийрав гэж нэг өвгөн байсан. Тэгээд цугаараа дор дороо зурхайч байсан. Урьд чинь сурсан юмаа гаргаад байдаггүй байсан юм. Нуучихдаг байсан. Би тийм юм мэддэг гэх юм байхгүй. Дилав хутагт, Нарбанчэн гэгээн хоёр манай хийдэд их л ойрхон ойрхон морилж ирдэг байсан.

Манайд Чогчэнгоос төвд ном барлана. Чойрын игчаанууд. Ер нь ховор ховор ном бартай байсан. Алтангэрэл, Жадамба, Сандуй зэрэг том том судрыг барлахгүй. Барын тусгай дуган гэж байгаагүй. Амь аминдаа байдаг байсан.

Хар болоод мал маллаж байсан. Би 1972 онд хот орж ирсэн. 1990 онд эргээд лам болсон. Дашчойлинд орохын өмнө Улиастайд байсан хийдэд хурсан. Би энэ бурханы номыг сайн сайхан болохоор нь өдий хүртэл дагаж яваа юм даа.